НИЙСЛЭЛИЙН
БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 14 өдөр Дугаар А/125 Улаанбаатар хот

Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх,
тэмцэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.4, 18.2.5, 18.2.10, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 61 дүгээр тушаал, Улсын Онцгой комиссын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн "Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, зарим арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цаг агаарын хуурайшилтын улмаас ой хээр, өнжмөл шар өвсний түймэр гарах эрсдэл нэмэгдсэнтэй холбогдуулан дүүргийн ногоон бүсэд ойн дагалт баялгийг ашиглах, аялал зугаалга, ууланд алхах, сургуулийн төгсөлтийн баярын арга хэмжээ болон ил задгай гал түлэхийг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэл зогсоосугай.

2.Ой, хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг дүүргийн хэмжээнд 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 10, 09 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

3.Ой, хээрийн түймэр унтраах зориулалтын багаж хэрэгсэл (тросон шүүр, цохиур, хүрз, хөрөө, сүх гэх мэт)-ийг нийт ажилчдынхаа 10 хувьд хүрэлцэхүйц хэмжээтэй бэлтгэн Онцгой байдлын хэлтэст 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор бэлэн болгож байршуулахыг нэр бүхий байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

4.Ой, хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор урамшуулалт морин эргүүл, хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулах, Онцгой байдлын хэлтсийн бие бүрэлдэхүүн, авто машин, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангахыг Онцгой байдлын хэлтэс (Г.Батжаргал)-т даалгасугай.

5.Ой, хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт явуулах хөдөлгөөнт эргүүлийн хуваарийг нэгдүгээр, Ой, хээрийн түймрийн аюулын үед дайчлагдан ажиллах аж ахуйн нэгж, байгууллагуудын хуваарийг хоёрдугаар, ой, хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх болон морин, хөдөлгөөнт эргүүлийн зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталж, ой, хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад шаардагдах 3,412,800 (гурван сая дөрвөн зуун арван хоёр мянга найман зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (П.Баттүшигт)-т зөвшөөрсүгэй.

1202010280

6.Хаврын хуурайшилтын улиралд ногоон бүсийн орчинд бүх төрлийн тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах ажил зохион байгуулахыг Цагдаагийн хэлтэс (Б.Эрдэнэбилэг)-т;

7.Дүүргийн хэмжээнд ой, хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлж сурталчлахыг Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Туяа)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, танилцуулж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Балжинням)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С.ДАВААСҮРЭН

Багануур дүүргийн Засаг даргын 2023
оны 04. дүгээр сарын 17-ны өдрийн
А/125 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх
хөдөлгөөнт болон морин эргүүлийн ажиллах хуваарь

Д/д	Байгууллага	Хугацаа	Явах маршрут	Хяналт тавих албан тушаалтан
1	Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Хороодын ажлын алба, Мал эмнэлгийн тасаг	2023.04.15,16 2023.05.06,07 2023.09.02,03	Дүүргийн Ногоон бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэд	ОБХ-ийн орлогч, ГХТББХАМ, ГХУХАБ-ч ахмад Д.Мөнхсайхан
2	Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Хороодын ажлын алба	2023.04.22,23 2023.05.13,14 2023.09.09,10	Хуцаа, Нарийны ам, Нүхэн зараа, Мандалын ам, Хэрлэн голын бургас, Мэлз зуслан	ОБХ-ийн ГТУА 64-р ангийн захирагч, ахмад С.Энхманлай
3	Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Хороодын ажлын алба	2023.04.29,30 2023.05.20,21 2023.10.01,02	Хил Залгаа Мөнгөнморьт, Баяндэлгэр, Цэнхэрмандал сумын нутаг	ОБХ-ийн орлогч, ГХТББХАМ, ГХУХАБ-ч ахмад Д.Мөнхсайхан
4	Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Хороодын ажлын алба	2023.05.20,21 2023.05.27,28 2023.10.07,08	Хуцаа, Нарийны ам, Нүхэн зараа, Мандалын ам, Хэрлэн голын бургас, Мэлз зуслан	ОБХ-ийн АССББСХМ ахмад П.Одонтуяа
5	Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Хороодын ажлын алба	2023.06.03,04 2023.10.14,15	Хуцаа, Нарийны ам, Нүхэн зараа, Мандалын ам, Хэрлэн голын бургас, Мэлз зуслан	ОБХ-ийн ГТУХБ ахмад Д.Ганболд
6	Урамшуулалт морин эргүүл	2023.03.20-06.10 2023.09.20-11.20	Хариуцсан хэсгийн нутаг дэвсгэрт	НБХГ-ын БОБ-ч Д.Ганбат

Багануур дүүргийн Засаг даргын 2023
оны .04. дүгээр сарын .14.-ны өдрийн
А/125 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

Ой, хээрийн түймрийн аюулын үед дайчлагдан ажиллах аж ахуйн нэгж, байгууллагуудын хуваарь

Д/д	Байгууллагын нэр	Гарах өдөр	Гүвүүр	Троссон шүүр	Хувин	Хүрз	Сүх	Усны сав (ш) (20л)	Хүний тоо	Хариуцсан	Хяналт тавих хүн
1.	Багануур ХК	04.01-04.10 09.20-09.25	10	10	10	10	2	5	10	Ц.Түвшинжаргал	ОБХ-ийн орлогч, ГХТББХАМ, ГХУХАБ-ч ахмад Д.Мөнхсайхан
2.	Улаанбаатар төмөр замын Багануур зангилаа	04.10-04.17 09.25-09.30	10	10	10	10	2	5	10	Н.Алтанхуяг	
3.	Багануурын дулааны станц ТӨХК	04.17-04.24 09.30-10.05	10	10	10	10	2	5	10	Н.Ганбаатар	
4.	Багануур-Ус ААТҮГ	04.24-05.01 10.05-10.10	10	10	10	10	2	5	10	Ж.Энхбат	
5.	Засаг даргын Тамгын газар	05.01-05.08 10.10-10.15	10	10	10	10	2	5	10	П.Баттүшиг	Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад Д.Ганболд
6.	Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Багануур цахилгаан түгээх сүлжээ салбар	05.08-05.15 10.15-10.20	10	10	10	10	2	5	10	Г.Шүрэнчулуун	
7.	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Багануур дүүргийн газар Монголын цахилгаан холбоо ХК-ийн Багануур дүүргийн Холбооны газар	05.15-05.22 10.20-10.25	10	10	10	10	2	5	10	Ц.Болормаа Б.Алтангэрэл	
8.	Багануур тохижилт ААТҮГ	05.22-05.27 10.25-10.30	10	10	10	10	2	5	10	Д.Олзвой	
9.	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Зүүн өмнөд бүсийн салбар	05.27-06.02 10.30-11.03	10	10	10	10	2	5	10	П.Ганбаяр	ГТУА 64 дүгээр ангийн захирагч, ахмад С.Энхманлай
10.	Багануур цахилгаан механикийн үйлдвэр ХХК	06.02-06.09 11.03-11.08	10	10	10	10	2	5	10	Э.Сайханбилэг	

Багануур дүүргийн Засаг даргын 2023
оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн
А/125 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх
хөдөлгөөнт эргүүлийн зардал

№	Явах чиглэл	Нэг эргүүлээр явах км	Нийт явах өдөр (километр)	Хэрэглээ (100 км-д 71л, 1л-д/түлш үнэ)	Нийт хэрэглээ (л)	Нийт мөнгөн дүн (төгрөг)
1	Дүүргийн ногоон бүс ойн сан	150 км	24*150=3600км	3950	648	2,559,600
2	Хил залгаа Баяндэлгэр, Мөнгөнморьт, Цэнхэрмандал сумдын нутаг	200 км	6*200=1200 км	3950	216	853,200
Нийт дүн			4800 км		864	3,412,800

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зардал
(урамшуулалт морин эргүүл)

№	Зардлын нэр	Хугацаа	Үнэ (төгрөг)	Тайлбар
1	Урамшуулалт морин эргүүл	2023.04.01-2023.06.01 2023.09.01-2023.11.02	200,000*4=800,000	4 сар ажиллана